



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/692

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 29 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөлийн Улсын Тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаанд “Хөх сувд 2024” мөсний баярын үйл ажиллагааны зохион байгуулалтын зардлын үлдэгдэл 600,000 (зургаан зуун мянган) төгрөг, Онцгой байдлын ерөнхийн газрын удирдлагын багаас хийсэн дадлага сургуулийн үерээр хэвлүүлсэн ажиллагааны зургийн зардал 180,000 (нэг зуун наян мянган) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012133